

Б.Галаарид: Хэвлэмэл сонин ирээдүйд үргэлж ялагч байр суурин дээр байна гэсэн дүгнэлт гарсан

Өдрийн сонин 2010.10.20 № 251 /3641/

Техник, технологийн хөгжлөө дагаад дэлхий нийтээр цахим мэдээллийн хэрэгсэлд хошуурч хэвлэмэл сонин, сэтгүүл хоцрогдох нь гэсэн ойлголт хүмүүст үүссэн. Тэгвэл “Хэвлэмэл сонин, сэтгүүл мөнхөд орших болно” гэсэн дүгнэлтийг саяхан Герман улсад болж өнгөрсөн “Дэлхийн редакторуудын XVII чуулган”-д оролцогчид гаргажээ. Энэ талаар тус хуралд оролцоод ирсэн “Глоб Интернэшнл” ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга, “Гэрэлт цалиг” сонины эрхлэгч Б.Галааридтай ярилцлаа.

- Дэлхийн редакторуудын уулзалтад та Монголоо төлөөлөн оролцоод иржээ. Энэ үеэр чухам юу яригдав?

- Германы Хамбург хотод энэ сарын 6-8-ны өдөр болсон уг чуулганд 77 орны 680-аад хүн оролцсон том арга хэмжээ болсон. Өмнө нь манайхаас хүн оролцож байсныг сайн мэдэхгүй байна ч энэ удаа би “Глоб Интернэшнл” байгууллагаа төлөөлж оролцоод ирлээ. Энэ чуулганаар ярилцсан хамгийн гол асуудал бол цаасан сонины цаашдын хувь заяа ямар байх вэ гэдэг асуудал байсан. Өөрөөр хэлбэл ирээдүйд хэвлэмэл сонин, сэтгүүл хэрхэн оршин тогтнох талаар мэргэжлийн судлаач, сэтгүүлчид болон цаасан сонинд ирээдүй байхгүй гэж үздэг цахим орчныг хэт шүтэгч хүмүүсийн төлөөлөгчид оролцож олон талаас шударгаар ярилцсан. Тэгээд цаасан сонин цаашдаа байх юм байна. Байх байхдаа үргэлж ялагч байр суурин дээр байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. АНУ-ын Нью-Йорк таймс, Францийн “le monde”, Египетийн “Аль Ахрам” мэдээллийн группын удирдах зөвлөлийн дарга, эрхлэгч нар гээд дэлхийн томоохон сонины төлөөлөгчид ирсэн. Азийн орнуудаас хамгийн том төлөөлөл нь мэдээж япончууд байсан. Японы хүн амын 90 хувь нь сонин уншдаг өндөр соёлтой орон. Нөгөө талаараа интернэт хөгжсөн Азийн хоёр орны нэг гэдэг утгаараа ихээхэн анхаарлын төвд байж, үндсэн болон туслах илтгэлүүд тавьсан. “Асахи шимбүн”-ы Гадаад мэдээний албаны дарга илтгэлдээ “Асахи шимбүн” өдөрт хоёр удаа хэвлэгддэг. Өглөөний хэвлэлт нь найман сая хувь хэвлэгдээд 7.9 сая нь зарагддаг. Гэтэл манайхаас олон 10 сая хувь гардаг “Ёми Үри шимбүн” байгаа” гэж хүмүүсийг инээлгэж байсан. Үүнийг “интернэт хөгжихийн хэрээр цаасан сонин байхгүй болдоггүй юм байна” гэдгийг амьдрал дээр харуулж байгаа тод жишээ гэж үзсэн.

- Хэвлэмэл сонины үнэ цэнэ чухам юундаа байгаа юм бол. Энэ тухай тодорхой ярьсан байх?

- Эндээс хоёр дүгнэлт гарч байгаа юм. Нэгдүгээрт чанарын асуудал. Ирээдүйд чанартай нь л оршино. Цаасан хэвлэлийг ялангуяа өдөр тутмын сониныг мэргэжлийн сэтгүүлчид чанарын өндөр түвшинд бэлтгэдэг. Энэ утгаараа уг мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэл, дамжин ирж байгаа мэдээллийг хүндэтгэх хүндлэл харьцангуй өндөр байдаг юм байна. Тэгээд ч хөгжилтэй оронд хэвлэмэл сонинд аль л чадвартай сайн сэтгүүлчийг өндөр цалинтай ажиллуулж байна. Тэр зардлыг онлайн орчин даахгүй. Тиймээс чанарын хувьд хэвлэмэл сонин ямагт тэргүүлэгч байх юм. Хоёрдугаарт рекламны хувьд уламжлалт хэвлэлд илүү итгэдэг. Телевизийн реклам зарим талаар сайн хүрдэг ч өндөр үнэтэй. Онлайн реклам үр дүн муу байна гэдгийг дэлхий нийтийн реклам түгээгчид судалгааны үндсэн дээр олж тогтоосон. Энэ утгаараа одоо эргээд хэвлэмэл сонин сэтгүүлийн реклам сайжирч эхэлсэн. Нөгөө талаар интернэт болоод орчин үеийн мэдээлэл түгээх янз бүрийн сувгууд ямар нэгэн хил хязгааргүй байдаг. Гэтэл аливаа зүйлд эрэг хашлага байх ёстой. Тэгвэл сэтгүүл зүй нь чанарын, ёс зүйн гээд олон төрлийн шалгуурт хашигдаж байдгаараа

хэвлэмэл сонин болоод мэргэжлийн сэтгүүл зүйг дахин илүү үнэлж эхэллээ. Хэвлэмэл сонин, сэтгүүлийг үл ойшоодог google-ийнхэн хүртэл бүгдээрээ хамтаръя гэсэн санаа хэлж байна лээ.

- Олон орны мэргэжил нэгтнүүдтэй уулзаж байхад хэвлэл мэдээллийн орчинд шинэ ямар чиг хандлага ажиглагдав. Сонины сэтгүүл зүй хувьд...?

- Сайн сэтгүүл зүй бол сайн бизнес мөн гэсэн томъёолол байдаг. Энэ утгаар нь авч үзвэл хэвлэмэл сонинд ирээдүй байна. Шинэ зүйл мэдээж ажиглагдлаа. Бүх төрлийн мэдээллийг агуулж байж л сонин гэж үздэг байсан бол одоо мэргэшсэн тодорхой сэдвээр дагнасан нарийн зааг ялгаа гарч эхэлж байгаа юм байна. Орон болгон өөрийн онцлогтой. Жишээ нь Испанид спортын сонин ид цэцэглэж, энэ сэдвээр бичиж байгаа сонин маш сайн борлогдож байх жишээтэй. Гэтэл Германд олон нийтийн эрх ашгийг хамгаалсан нийтлэлийн бодлого барьдаг сонинууд, ОХУ-д өдөр тутмын гэхээсээ илүүтэй 10 хоног тутмын сонинууд илүү борлуулалттай байгаа юм байна. АНУ-д бол янз бүрийн түүх бичсэн сонин сайн борлогдож байна. Түүх гэдэг нь өнгөрсөн цаг дээр биш. Мэдээ мэдээлэл үйл явдлыг түүх гэж хэлдэг. Үйл явдлын тухай бичнэ гэж ярихаасаа илүүтэй түүх бичнэ гэж ярьдаг болсон байна. Мөн “бидний өмнө ийм асуудал тулгарч байна, Ийм асуудлыг шийднэ” гэж ярьдаг байсан бол одоо “дуудлага” гэж ярьж байх жишээтэй. Өөрөөр хэлбэл “Ийм шийдвэл зохих зүйл биднийг өдөж байна, дуудаж байна” гэж ярих жишээтэй. Энэ мэтчилэн үг томъёо, нэршил хүртэл өөрчлөгдөж байна.

- Уг чуулганы үеэр “Алтан үзэг”-ний шагнал гардуулах ёслол болдог гэсэн. Хаанахын ямар хүн хүртэв?

- Дэлхийн сонин холбооноос олгодог энэ шагналыг өнөө жил Ираны сэтгүүлч Ахмад Зед Абад олгосон. Энэ хүн Ираны одоогийн засгийн газрыг шүүмжилж бичсэнийхээ төлөө зургаан жилийн ял сонсоод одоо шоронд хоригдож байгаа юм байна. Иранд сэтгүүлчдэд ингэж жил зааж ял өгөхөөсөө гадна бүх насаараа мэргэжлийн ажлаа хийх эрхийг нь хасчихдаг харгис хуультай юм байна. Өнөөдөр дэлхий даяар 115 сэтгүүлч шоронд байгаагийн 22 нь Иранд байдаг. Хэвлэлийн эрх чөлөөний шалгуураар авч үзэхэд Иран хамгийн аймшигтай шоронгийн орон болчихоод байгаа тухай энэ үеэр онцолж байсан. 2006 онд “Алтан үзэг” шагналыг мөн Ираны зохиолч нийтлэлч, Акбар Ганжи гэдэг хүн авсан байдаг. Энэ хүн 18 сар хоригдоод эх орноосоо цагаачлаад гарчихсан юм билээ. Акбар Ганжи энэ жилийн чуулганд оролцож Ираны нөхцөл байдлын тухай яриад мэргэжил нэгт андынхаа шагналыг гардаж авсан. Энэ дашрамд мэргэжил нэгтнүүддээ дуулгахад Дэлхийн редакторуудын дараагийн чуулган ирэх оны аравдугаар сард Австрийн Венад болно. Үүнтэй дэлхийн сонинуудын 63 дугаар конгресс, “Info service- 2011” экспо давхцаж гурван том арга хэмжээ нэгэн зэрэг болох гэж байна. Би олон хуралд сууж байсан. Энэ хуралд суух нь хамгийн богино хугацаанд үр дүнтэй их мэдээлэл өгдөг юм байна. Тиймээс сонин редакторуудад ирэх жил болох хурлыг судалж чих тавьж аль болох олноор оролцоосой гэж хүсч байна.

Д.Цогзолмаа